

“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн  
2023 оны 02 сарын 16 өдрийн хурлын  
06/2023 дугаар тогтоолын хавсралт



БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА

Ц.ЗОРИГТ

## “УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү бодлогын чиглэлээр компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 1.2 Бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдсэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.

### Хоёр. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-д танилцуулна.
- 2.2 Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаал болон нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж санал болгоно.
- 2.4 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.5 Өндөр насны тэтгэвэрт гарах бол таамаглаж болохуйц сул орон тоонд нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

### Гурав. БУСАД

- 3.1. Энэ баримт бичгийн хэрэгжилтэнд хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт оруулах эрхийг эдэлнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ